

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН УЛСЫН ДУГААРЫН ТЭМДЭГ ҮЙЛДВЭРЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх санхүү, эдийн засгийн чадавхтай байх /татварын байгууллагад өргүй, тайлан баланс зөрчилгүй г.м. татварын албаны тодорхойлолт/;
2. Стандартын шаардлага хангасан, дугаарын үйлдвэрийн тоног төхөөрөмж, тэдгээрийн техникийн баримт бичиг;
3. Тоног төхөөрөмж нь “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. Ерөнхий шаардлага” MNS4410:2002, стандартад заасан дугаарын тэмдгийн хэлбэр, хэмжээ, тоо, үсэг хоорондын зайн хэмжээсийг өөрчлөх боломжгүйгээр үйлдвэрлэх шаардлагыг хангасан байх;
4. Өөрийн буюу түрээсийн, үйлдвэрлэл үйлчилгээний ажлын байртай байх;
5. Ажлын байрны галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан тухай дүгнэлт;
6. Дугаарын бэлдцийн ар талд байх тухайн үйлдвэрийн таних тэмдгийн загвар, тээврийн хэрэгслийн гэрчилгээ дээр тэмдэглэл хийх зориулалтын дардастай байх;
7. Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэсэн мэдээллийг эрх бүхий байгууллагатай солилцох цахим сүлжээ нэвтрүүлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлсэн байх;
8. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар/;
9. Ажилтнуудыг ажилд томилсон тухай шийдвэр; /ажилтнуудын анкет, мэргэжлийн үнэмлэх, хөдөлмөрийн гэрээ, дугаарын үйлдвэрийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадвартай, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байх г.м./;
10. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ аж ахуйн нэгж, байгууллага нь Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана